



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2025 оны ээлжит 05 дугаар хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 05 дугаар хуралдаан 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 05 дугаар хуралдаанаар /2025-03-17/ Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 7 (Тогтоол №58-64, 2025-03-17) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 05 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 7 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 7 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 58 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдэд 3 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 59 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Эф Си Эс экспресс ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх, Монгол Улс- БНСУ чиглэл) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 60 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг (Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.1, 1.3 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх хэсэг, 30

дугаар зүйлийн 30.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 61 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн (Сарны чулуу анар ХХК; Эгон ХХК; Миний Монгол энтертэймент ХХК; Говийн долгион мэдээллийн төв ТББ) 4 тусгай зөвшөөрлийг 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Мобиком корпораци ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 62 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Мобиком корпораци ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Түгээмэл шуурхай шуудан ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 63 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Түгээмэл шуурхай шуудан ХХК: Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 64 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн (Билэгт дөлгөөн ХХК; Монгол шуудан ХК) 2 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтыг 2 жилийн хугацаатай тус тус сунган шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2025-03-24